



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/191

Мандалговь

“Ашид бьюлдинг” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Бизнес эрхлэгчдийг дэмжих төвийн их засвар”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Ашид бьюлдинг” ХХК-тай 542,663,262 (таван зуун дөчин хоёр сая зургаан зуун жаран гурван мянга хоёр зуун жаран хоёр) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан зураг, төсвийн дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Ашид бьюлдинг” ХХК-ний захирал (Д.Нэргүй)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150432